

**“МИК Холдинг” ХК-ийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл**

Хурал болсон газар: “МИК ОССК” ХХК-ийн байранд

Хурал болсон он, сар, өдөр: 2016 оны 04 дүгээр сарын 28-ны Пүрэв гараг

Хурал болсон цаг: 10 цаг 25 минут

Хурлын дарга: Лхагважав овогтой Гантөмөр

Хурлаар хэлэлцсэн асуудал:

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
2. ТУЗ-ийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
3. Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг батлах тухай;
4. Компанийн ТУЗ-ийн зардлын 2016 оны төсвийн төслийг батлах тухай;

Хурлын ирц: 96,24 хувь

Хуралд биечлэн болон урьдчилан саналын хуудсаар оролцогчид:

№	Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт	Энгийн хувьцааны тоо ширхэг	Хурлын ирцын хувь
Хувьцаа эзэмшигч ИРГЭН			
1	Д.Янжмаа	16	0,0000773%
2	Х.Лхагвасүх	2	0,0000097%
3	Ж.Баатар	15	0,0000724%
4	Б.Гантулга	2	0,0000097%
5	Б.Цэрэнжав	16	0,0000773%
6	Д.Өлзийбат	41	0,0001980%
7	Ч.Халтмаа	100	0,0004829%
8	Г.Ундармаа	1 000	0,0000000%
9	Г.Гонгор	5	0,0000000%
10	Н.Туул	16	0,0000000%
11	Г.Сансар	31	0,0000000%
12	Н.Эрдэнэчимэг	10	0,0000000%
13	З.Эрдэнэцацрал	200	0,0009657%
14	Л.Өнөржаргал	1	0,0000048%
15	Ч.Батаа	49	0,0002366%
16	Э.Алтаншагай	3	0,0000145%
17	Д.Батсайхан	17	0,0000821%
Хувьцаа эзэмшигч ХУУЛИЙН ЭТГЭЭД			
18	Монгол улсын хөгжлийн банк	3 081 955	14,88%
19	Монгол банк	421 241	2,03%

20	Хаан банк	210 621	1,02%
21	"Централ Эйшиа Инвестмент" ХХК	81	0,000391%
22	Хас банк	210 621	1,02%
23	ХХБанк	5 310 938	25,65%
24	УБ Хотын банк	5 934 980	28,66%
25	Юнайтэд Секьюритис ХХК	371 155	1,79%
26	"Ти Ди Би Капитал" ХХК	1 552 726	7,50%
27	Капитал банк	1 680 948	8,12%
28	Голомт банк	1 153 699	5,57%

Л.Гантөмөр: Сайн байцгаана уу, та бүхэнд энэ өглөөний мэндийг хүрье. “МИК Холдинг” ХК-ийн 2016 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн ТУЗ-ийн хурлын 16/24 тоот тогтоолоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг өнөөдөр буюу 4 дүгээр сарын 28-ны өдөр зарлан хуралдуулах шийдвэрийг гаргасан. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга М.Мөнхбаатар гадаад улсад томилолтоор ажиллаж байгаа тул “МИК Холдинг” ХХК-ийн 2016 оны ТУЗ-ийн хурлын 16/26 тоот шийдвэрээр намайг хурлын даргаар томилсон. Энэ удаагийн хурлын тооллогын комиссын дарга болон гишүүдийг танилцуулъя. Тооллогын комиссын дарга, С.Амарсайхан. Тооллогын комиссын гишүүдээр Ж.Элбэгсайхан, Х.Маргад-Эрдэнэ, Т.Одгариг, Б.Болортуяа, Т.Одгаригийг тус тус томилсон байна. За ингээд тооллогын комиссын дарга, С.Амарсайхан хурлын ирцийг танилцуулна уу.

С.Амарсайхан: Сайн байцгаана уу. Тооллогын комиссын дарга Амарсайхан байна. Та бүхэнд ирцийг танилцуулъя. “МИК Холдинг” ХК-ийн 2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 7,678,660 ширхэг буюу 37.08 хувийн энгийн хувьцаа эзэмшигч биеэр оролцож байна. 4,635,743 ширхэг буюу 23.08 хувийн энгийн хувьцаа эзэмшигч саналын хуудсаар саналаа урьдчилан өгсөн байгаа. Нийт саналын эрх бүхий 20,709,320 ширхэг энгийн хувьцаа эзэмшигчдээс 60,08 хувийн ирцтэй байгааг мэдээлж байна.

Л.Гантөмөр: Тооллогын комиссын даргад баярлалаа. Хурлын ирц хүрсэн тул энэ удаагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг албан ёсоор нээж байна. Хуралтай холбоотой материалууд нийт хувьцаа эзэмшигчдэд тараагдсан байгаа. Нийт 4 хэлэлцэх асуудал байгаагаас 3 асуудалд Хувьцаа эзэмшигчдээс шийдвэр гаргуулах юм. Үлдсэн нэг асуудал нь ТУЗ-ийн хурлаас гарсан тогтоолыг танилцуулах болно.

Нэгдүгээр асуудал: “МИК Холдинг” ХК-ийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай

Асуудал танилцуулсан хүний нэр, албан тушаал: Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Л.Гантөмөр.

Асуудал хэлэлцэхэд оролцсон хүмүүсийн нэр, албан тушаал:

Хэлэлцэж байгаа асуудлаар асуулт асууж, санал гаргасан хүмүүсийн нэр албан тушаал, асуулт ба гаргасан саналын талаарх тэмдэглэл

Л.Гантөмөр: “МИК Холдинг” ХК-ийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг уншиж танилцуулъя. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсэг, 76.1.11 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэг, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.7.15 дахь заалт, “МИК Холдинг” ХК-ийн 2015 оны санхүүгийн тайланг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас тогтоох нь: 1. “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийн гаргасан 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгдсэн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй. 2. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж зохих шийдвэрийг гаргуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (М.Мөнхбаатар)-д даалгасугай. 3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын албаны дарга (Ж.Онон)-д үүрэг болгосугай. Санхүүгийн тайлантай холбоотой асуудалд хувьцаа эзэмшигч та бүгд асуулт асууж болно. Хэрэв та бүгдэд асууж тодруулах зүйл байхгүй бол энэхүү хэлэлцэж буй асуудалтай холбоотой Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Нэг асуулт байна. Хурлын даргыг танилцуулахгүй юм уу?

Л.Гантөмөр: Хурал эхлэхээс өмнө би өөрийгөө танилцуулсан.

Л.Оюун-Эрдэнэ: Өөрөө даргалж байгаа юм уу?

Л.Гантөмөр: Тийм.

Т.Цогтбаяр: Компанийн үйл ажиллагааны тайлан, товч дүгнэлтийг танилцуулсны дараа хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулбал яасан юм бэ? Тайлангууд нь бол ирсэн байна л даа. Гэхдээ одоо хариуцсан хүн нь эсхүл гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн дарга нь ерөнхийдөө үйл ажиллагааны талаар товч, хураангуй танилцуулж болох уу? Танилцуулсны дараа хэдүүлээ тогтоолын төсөлд саналаа хэлж болох юм.

Л.Гантөмөр: Тэгье.

Т.Цогтбаяр: Зарим асуумаар зүйл байгаа шүү дээ. Асуудлыг танилцуулахгүйгээр шууд тогтоолын төслийг танилцуулах биш, харин гол хариуцсан Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн дарга гэх хүмүүсээс оруулж ирээд, ялангуяа дүгнэлтийн талаар товч танилцуулга хийвэл зүгээр байна л даа. Мөн хурлыг хурдан явуулахын тулд бүх асуудлыг нэг дор танилцуулаад, дараа нь асуулт хариулт шүүмжлэл байвал хэлэлцээд, хамгийн сүүлд нь тогтоолын төслүүдийг унших саналтай байна.

Л.Гантөмөр: Хурлын дэгтэй холбоотой асуудал, яаж саналаа өгөх вэ? гэдгийг тооллогын комисс танилцуулах уу?

С.Амарсайхан: Нийт гурван асуудлыг хэлэлцэж саналаа өгөхөөр байгаа. Гурван асуудал тус бүрд саналаа өгөх нийт нэг саналын хуудас та бүгдэд өгсөн. Батлагдсан хурлын дэгийн дагуу нийт 3 асуудлыг хэлэлцсэний дараа саналын хуудсыг нэгдсэн байдлаар бөглөж өгөх юм.

Л.Гантөмөр: Компанийн үйл ажиллагааны тухай материал нийт хувьцаа эзэмшигчдэд тараагдсан байгаа. Үүн дээр нэмээд Компани 2015 онд юу хийсэн бэ? гэдэг тухайд та бүгдэд товчхон мэдээлье. Компанийн үндсэн үйл ажиллагаа бол маш тодорхой юм. Орон сууцны зээл буюу ипотекийн хоёрдогч зах зээлийн эргэлтэд оруулах, түүнийг худалдан авах, үнэт цаас гаргах зорилгоор 2006 онд арилжааны банкууд хамтран үүсгэн байгуулсан. 2015 онд “МИК Актив Дөрөв ТЗК”, “МИК Актив Тав ТЗК”, “МИК Актив Зургаа ТЗК”, “МИК Актив Долоо ТЗК” ХХК гэсэн 4 тусгай зориулалтын компаниудаараа дамжуулан нийтдээ 1,3 их наяд орчим төгрөгийн орон сууцны зээлийг багцлан худалдан авсан. Одоогоор нийт худалдан авсан орон сууцны зээлийн багц 2,1 их наяд төгрөг болсон байна. 2014 онд гэхэд Компанийн 800-аад тэрбум төгрөгийн активтай байсан бол 2015 онд 2 их наяд төгрөгийн активтай болсон буюу 2 дахин өсөлтийг үзүүлсэн. Санхүүгийн гол үзүүлэлтүүд иймэрхүү байдалтай байна. “МИК

Холдинг” ХК болон охин компаниудын 2015 оны ашгийн үзүүлэлт 30 орчим тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай гарсан. Хамгийн том хийсэн үйл ажиллагаа бол 2015 оны 12 сард нээлттэй компани болсон. Үүнтэй холбоотойгоор 37 тэрбум төгрөгийн IPO хийж хөрөнгө оруулагчдаас нэмж хөрөнгө татсан. Энэхүү татан төвлөрүүлсэн хөрөнгийг үндсэн үйл ажиллагааны зорилгын дагуу ипотекийн зах зээлийг хөгжүүлэх, зээлийн багц худалдан авч үнэт цаас гаргах үйл ажиллагааг үргэлжлүүлэхэд хөрөнгө оруулж байгаа. 2016 он гараад эхний нэг зээлийн багц худалдан авалт хийгдсэн. Дараа дараагийн зээлийн багц худалдан авах ажил эхлээд явж байгаа. Товчхондоо гэвэл компанитай холбоотой санхүүгийн үйл ажиллагаа хэвийн түвшинд үргэлжилж байна. Эрнст энд Янг Монголиа Аудитын ХХК-иас гаргасан дүгнэлтийг та бүгдэд товчхон уншиж өгөх үү, эсхүл та бүгд уншиж танилцсан байгаа юу? Та бүгдэд тараасан материалын 17 дахь хуудсанд байна. *Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Группийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна* гэж компанийн санхүүгийн үйл ажиллагааг Эрнст энд Янг Монголиа Аудитын компаниас дүгнэсэн. Энэхүү дүгнэлтийг ТУЗ хүлээж аваад та бүгдэд уншиж танилцуулсан ТУЗ-ийн тогтоолыг гаргасан. Одоо ТУЗ-аас гаргасан энэ тогтоолыг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр батлах юм. Та бүгдэд нэмж тодруулах асуулт байна уу?

Б.Цэрэнжав: Надад 2 асуулт байна. 1-рт Эрнст энд Янг Монголиа Аудитын компанийг ямар шалгуураар сонгож авсан юм бэ? Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК их өндөр үнэтэй аудит хийдэг компани юм байна. Миний мэдэхээр их олон луйварчдыг тэжээдэг компани гэж ойлгодог. 2-рт Саяхан ирээдүйн тэтгэврийн нөөц санд танай компани тодорхой хэмжээний хөрөнгө шилжүүлсэн тухай сонссон. Энэ тухайд хаана, ямар шийдвэрээр, юуг үндэслэж хэчнээн хэмжээний, хэдэн төгрөг шилжүүлсэн бэ?

Л.Гантөмөр: Эрнст энд Янг Монголиа Аудитын компани бол олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дэлхийн топ компаниудын нэг юм. Компанийн үйл ажиллагааны зорилго, чиглэл, алсын хараа бол зөвхөн дотооддоо үйл ажиллагаа явуулах биш, Монгол улсад олгогдсон ипотекийн зээлийн багцыг гадаад улсад үнэт цаасжуулах хэлбэрээр олон улсад үйл ажиллагаа явуулах хэтийн төлөвлөгөө байгаа учраас дотоодын аль нэг аудитын компани биш гадны компаниар аудит хийлгэх шаардлага тавигдана. Сүүлийн жилүүдэд бид Эрнст энд Янг Монголиа Аудитын компаниар аудит хийлгэж байгаа. ХХК байхдаа аудит хийлгэж байсан, ХК болохын өмнө 9 дүгээр сард мөн аудит хийлгэсэн. За 2-р асуултад хариулъя. Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай шинэ хууль батлагдсаныг та бүгд мэдэж байгаа байх. Монголбанк болон Засгийн газрын хамтран хэрэгжүүлж байгаа орон сууцны ипотекийн хөтөлбөр +8 гэсэн хөтөлбөр байгаа. Одоо бол +8, +5 хөтөлбөр болж байгаа. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Засгийн газар буюу ирээдүйн тэтгэврийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хууль тогтоомж, шийдвэр гарсан. Үүнтэй холбоотой ипотекийн 8 хувийн зээл олгох эх үүсвэрийг Монголбанк гаргадаг байсан бол ирээдүйн тэтгэврийн сангаас санхүүжилт өгдөг болсон. Бид буцаагаад тэр санд нь гаргасан үнэт цаасаа эзэмшүүлэх тогтолцоотой болсон. Энэ тухайд компани ямар нэгэн мөнгө шилжүүлсэн юм байхгүй. Компани өөрийн эзэмшиж байгаа үнэт цаасны багцыг шилжүүлж, оронд нь олгосон байгаа 8, 5 хувийн зээлийн багцын худалдан авалт хийгдсэн. Монголбанк нэг оролцогч нь байсан бол түүний оронд ирээдүйн тэтгэврийн сан болж бүтцийн өөрчлөлт хийгдсэн асуудал байгаа юм. Түүнээс биш компанийн хөрөнгийг ийш тийш нь шилжүүлсэн тохиолдол байхгүй.

Ж.Баатар: Би нэг зүйл асууя. 2 дахь багцыг гаргахаар бэлтгэж байгаа гэсэн. Энэ талаар дэлгэрэнгүй тайлбар өгнө үү.

Л.Гантөмөр: Үнэт цаасны юу?

Ж.Баатар: Тийм.

Л.Гантөмөр: 2 дахь багц гэдэг маань компанийн 2015 оны 12 дугаар сард IPO хийж 37.2 тэрбум төгрөг босгосон. Энэхүү татан төвлөрүүлсэн хөрөнгийг ямар үйл ажиллагаанд зарцуулж байгаа вэ гэхээр 8 болон 5 хувиас ялгаатай, банкууд өөрсдийн эх үүсвэрээ олгосон байгаа зээлүүдийг худалдан авах үйл ажиллагаанд зарцуулж байгаа юм. Эхний хэлцэл нь 2016 оны 3 дугаар сард хийгдсэн. Үнийн дүн нь 2 орчим тэрбум төгрөгийн багц худалдан авсан. Дараагийн багцын шинжилгээ хийгдээд явж байгаа. Банкуудад олгогдсон нийт 5 орчим төгрөгийн орон сууцны зээлийг худалдан авахаар төлөвлөөд байгаа юм. Үндсэндээ тэр мөнгөөр бид ямар үйл ажиллагаа хийгээд байна вэ гэхээр банкуудын олгосон өндөр хүүтэй орон сууцны зээлүүдийг худалдан авч байгаа гэсэн үг юм. Энэ худалдан авалт бол буцаан солих нөхцөлтэй. Хэрвээ бидний худалдан авсан орон сууцны зээл төлөгдөхөөргүй болсон бол компани эрсдэл хүлээхгүй, анх олгосон банкинд нь буцаан худалдах юм. Бусад 5, 8 хувийн орон сууцны зээлийг худалдан авч байгаа процесс бол Засгийн газрын хэрэгжүүлж байгаа хөтөлбөрт багтсан үйл ажиллагаа юм.

Т.Цогтбаяр: 1-рт Компанийн бүтцэд нийтдээ 9 тусгай зориулалтын компани байна. Эдгээрээс 7 тусгай зориулалтын компанийг баланст бүртгэсэн байна. Тэгэхээр 8, 9 гэсэн хоёр тусгай зориулалтын компанийн бүртгэл хаана явж байна вэ? Энэ баланс дээрээ тусгаагүй байгаа юм уу, эсхүл банкуудад байж байдаг юм уу? 2-рт Сан болгоны өгөөж бидэнд чухал л даа. Хэдий хэмжээний өгөөжтэй, бидэнд хэдэн хувь хэмжээний орлого авчрах талаар мэдээлэл энэ дотор алга байна. Энэ талаар мэдээлэл өгнө үү. Нийт худалдан авалтын хэлцлийн дүн 2,1 их наяд төгрөг болсон гэж байна. Үүнийг тус тусад нь актив активээр нь танилцуулж болох уу?

Л.Гантөмөр: Яг одоо надад актив тус бүрийн худалдан авалтын хэлцлийн дүн алга байна. Гэхдээ нийтдээ багцаар нь ойлгомжтой танилцуулъя. 2015 онд 7 тусгай зориулалтын компани (ТЗК) нийт 2,1 их наяд төгрөгийн дэд хөтөлбөрийн орон сууцны зээл багцлан худалдан авч, оронд нь яг энэ үнийн дүн бүхий ипотекийн зээлээр баталгаажсан бонд гаргасан. Маш товчхондоо хэлэхэд энэ хоёрын хүүний зөрүүгээр тухайн ТЗК-ийн ашиг тодорхойлогдож цаашдын ипотекийн зээлийн үйл ажиллагааг үргэлжлүүлдэг. Насжилтын хувьд ТЗК тус бүрийн орон сууцны зээлийн хугацаанаас шалтгаална. Тэр болтол тухайн ТЗК-ийн хуримтлагдсан мөнгөн хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд тараах нь хориотой байгаа. Үүнийг хэзээ тарааж болдог вэ гэвэл компани татан буугдах эсхүл ТЗК үйл ажиллагааныхаа зардлыг нөхөж чадахаа болиод ашигтай биш ажилласан тохиолдолд буцаагаад орон сууцны зээлийг худалдан авч компанийг татан буулгах юм. Энэ нь өөрсдийн санаачлагчаар эсхүл үйл ажиллагааны хугацаа нь дууссан үед ТЗК-иуд татан буугдвал тухайн ТЗК-иас үлдсэн цэвэр мөнгөн хөрөнгийг хувьцаа эзэмшигч нарт ногдол ашиг болгон тараах юм. Үүнийг орон сууцны зээлийн дундаж насжилттай харьцуулаад үзэхэд ойролцоогоор 7-8 жил гэж харж байгаа. Хамгийн эхний ТЗК байгуулагдаад 3 жил болох гэж байна. Тэгэхээр нийт хөрөнгө оруулагчид ТЗК-иас ногдол ашиг авах дундаж хугацаа нь одоо бидний тооцож эхэлсэн хугацаанаас хойш 3 жил, 3 жил хагасын дараагаар байх болов уу гэж харж байгаа. Одоо тарааж буй ногдол ашиг бол компанийн орон сууцны зээлийн дэд хөтөлбөртэй хамааралгүйгээр “МИК ОССК” ХХК-ийн цэвэр ашгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хэлбэрээр тарааж байгаа юм. Энэ тухайд хувьцаа эзэмшигч та бүгд зөв ойлголттой байх нь зүйтэй. 2016 оны дунджаар улиралд 500-600 тэр бум төгрөгийн орон сууцны ипотекийн зээлийг багцлан худалдан авах төлөвлөгөөтэй байгаа. 2017 оны сүүлээр гэхэд манай худалдан авсан зээлийн багцын хэмжээ 4 их наяд төгрөгт хүрнэ гэсэн төсөөлөлтэй байгаа. Байгуулагдсан ТЗК бүр тус тусдаа баланстай. Одоогоор МИК Актив ТЗК Нэг-Ес хүртэлх ТЗК байгуулагдсан байгаа. 2015 оны аудитын дүгнэлтээр нийт хөрөнгийн

хэмжээнд “МИК Холдинг” ХК, “МИК ОССК” ХХК болон түүний охин компаниуд болох ТЗК-иудыг нэгтгэсэн тайлан гарсан. Хэрэв шаардлагатай гэвэл охин компаниудын тайлан нээлттэй байж болох байх.

Т.Цогтбаяр: Би компанийн вэбсайт үзсэн. ТЗК болгоны ерөнхий танилцуулгыг харсан. Гэхдээ хувьцаа эзэмшигч нарт зориулан ТЗК тус бүрийн дундаж өгөөж, үндсэн орлого, хүүний талаар товч, хураангуй мэдээллийг нэмж оруулбал зүгээр байна. Вэбсайт дажгүй байна лээ.

Л.Гантөмөр: Нийтэд мэдээлэх ёстой мэдээллийг бид мэдээлэхэд татгалзах зүйлгүй. Үүнийг компани дотроо гүйцэтгэх удирдлагын түвшинд ярилцаад шийдэх байх. Хувьцаа эзэмшигч та бүгдээс өөр нэмж тодруулах зүйл байна уу? Байхгүй бол тогтоолын төслийг уншиж танилцуулъя. *Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ГҮЗ-ийн дүгнэлтийг батлах тухай. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг 62.1.9 дэх заалт, “МИК Холдинг” ХК-ийн дүрмийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, МИК Холдинг ХК-ийн 2016 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 16/21 тоот тогтоолыг тус тус үндэслэн “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоох нь: 1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан болон “Эрснт энд Янг Монголия Аудит” ХХК-ийн гаргасан 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгдсэн санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Л.Гантөмөр гэсэн байна.* Тогтоолын төсөлд санал хэлэх хүн байна уу?

Э.Алтаншагай: Санхүүгийн тайланд 2015 онд 125 тэрбум төгрөгийн хүүний орлого олсон гэж байна. Хүүний зардал гэсэн байгаа нь яг юуг хэлж байгаа юм бэ?

Л.Гантөмөр: Хүүний орлого гэдэг бол компанийн эзэмшиж байгаа нийт худалдан авсан орон сууцны зээлийн багцаас орж ирж байгаа хүүний орлого юм. Үүний эсрэг компани хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас буюу урт хугацаат бонд гаргасан. Энэхүү гаргасан бонд нь 10,5 болон 4,5 хувийн хүүтэй 2 төрлийн үнэт цаас юм. Эдгээрт төлөгдөж байгаа бондын хүүний төлбөр нь хүүний зардал юм. Компанийн худалдан авсан зээлийн багц дунджаар 15 орчим хувийн хүүтэй, хөтөлбөрийн хүрээнд худалдан авсан зээлийн багц 8 хувийн хүүтэй юм.

Э.Алтаншагай: Хүүний орлого гэдэг нь 8 хувийн хүүний орлогыг нийт дүнгээр нь бодоод байгаа юм байна, тийм үү?

Л.Гантөмөр: Тийм.

Э.Алтаншагай: Хүүний зардал гэдэг нь банкуудаас тодорхой хэмжээний хүү авч байгаа, тэрийг л хасаад байна уу?

Л.Гантөмөр: Үгүй. Банкуудаас хүү авч байгаа юм байхгүй. Эзэмшиж байгаа орон сууцны зээлийн багцын хүүг авч байгаа. Тэрний эсрэг гаргасан үнэт цаасныхаа хүүг төлж байгаа юм. Бондын хүү бол 10 хувь нь 10,5 хувийн хүүтэй. Үлдсэн 90 хувь нь 4,5 хувийн хүүтэй юм. Тэр 4,5 хувийн хүүтэй бондыг өмнө нь Монголбанк эзэмшиж байсан бол одоо Ирээдүйн тэтгэврийн нөөц сан эзэмшдэг болсон. Та бүгдэд тогтоолын төсөлтэй холбоотой өөр асуух зүйл байна уу? Байхгүй бол хоёрдугаар асуудлыг хэлэлцье.

Э.Алтаншагай: 2016 онд Ипотекийн зээл авах иргэдийн эрэлт байгаа эсэхэд хийсэн судалгаа байгаа юу?

Л.Гантөмөр: Багц тоогоор хэлэхэд ойлгомжтой болох байх. Зах зээлд нийт 3 их наяд төгрөгийн орон сууцны зээл байснаас 2 их наяд төгрөгийн орон сууцны зээлийг худалдан авсан. Цаашид 2016 онд 2 их наяд төгрөгийн зээлийг шинээр нэмж худалдан авах, 2016 оны эцэс гэхэд 4 их наяд төгрөгийн орон сууцны зээл худалдан авсан байх төсөөлөлтэй байгаа. Хэрэв биднээс хамаарахгүйгээр зохицуулагч байгууллагуудаас орон сууцны зээлийн дэд хөтөлбөртэй холбоотой янз бүрийн шийдвэр гарчихгүй бол бидний төсөөллөөр үргэлжлэх байх. Ер нь зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа компанийн хувьд зах зээлийн судалгаа, шинжилгээг хариуцсан газар нэгж нь тус бүртээ хийгээд түүнээс

гарсан үр дүнд санхүүгийн тайлан шинжилгээ, төсөөлөл, тооцооллуудыг хийдэг. Манай компани зах зээл дээр 10 жил тасралтгүй, тогтвортой үйл ажиллагаа явуулсан, энэ үйл ажиллагаагаар мэргэшсэн компани гэж хэлж болохоор тул бидний төсөөлөл харьцангуй бодитой байдаг.

Э.Алтаншагай: Бонд гаргаад 4 хувийн хүүний зардал гарч байгаа гэсэн. Тэр хүүг ямар байгууллагад төлдөг юм бэ?

Л.Гантөмөр: Тэр хүүний орлогыг одоо Тэтгэврийн ирээдүйн нөөц сан руу шилжүүлж байгаа юм.

Э.Алтаншагай: Сая шилжүүлсэн 7 тэрбум төгрөг юм уу?

Л.Гантөмөр: Тийм. Хуучин бол энэ хөтөлбөрийн эх үүсвэрийг Монголбанк олгоод тэгээд арилжааны банкууд 8%-ийн зээлээ олгоод тэр зээлийг “МИК ОССК” ХХК-ийн охин компани болон ТЗК худалдаж авч ипотекийн зээлээр баталгаажсан бонд гаргадаг. Нийт гаргасан бондын 90% буюу эрхтэй эрхтэй бондыг Монголбанк үлдсэн 10 % банкууд эзэмшиж байсан бол одоо Монголбанк эзэмшиж буй 90% бондоо Хүн Ам Хөгжил Нийгэм Хамгааллын яам буюу Ирээдүйн тэтгэврийн санд шилжүүлсэн байгаа.

Э.Алтаншагай: Тэр нь хүүг нь яах уу?

Л.Гантөмөр: Санд хуримтлагдсан байгаа хөрөнгөөр дараагийн орон сууцны зээлийг санхүүжүүлнэ. Төлөгдөж байгаа мөнгөнөөсөө хамаарч нийлүүлэлт хийж эхэлнэ гэсэн үг.

Хоёрдугаар асуудал: ТУЗ-ийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;

Асуудал танилцуулсан хүний нэр, албан тушаал: Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Л.Гантөмөр.

Асуудал хэлэлцэхэд оролцсон хүмүүсийн нэр, албан тушаал:

Хэлэлцээж байгаа асуудлаар асуулт асууж, санал гаргасан хүмүүсийн нэр албан тушаал, асуулт ба гаргасан саналын талаарх тэмдэглэл

Д.Гантөмөр: Хоёрдугаар асуудлын хувьд зөвхөн танилцуулах ёстой асуудал байгаа тул та бүхэнд уншиж танилцуулъя. 2016 оны 3-р сарын 18-ны 16/22 Ногдол ашиг хуваарилах тухай, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 47 дугаар зүйл, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.2 дах хэсэг, Аж ахуйн нэгжсийн орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.1 дах хэсэг, 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх хэсэг Санхүүгийн зохицуулах хороо 2003 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 65 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилалтад хяналт тавих тухай журам” болон Компанийн дүрмийн 24 дүгээр зүйлийн 24.2. дах хэсэг, МИК Холдинг ХХК-ийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 15/03 тоот тогтоолоор батлагдсан “МИК Холдинг ХХК-ийн Ногдол ашгийн бодлогыг, тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас тогтоох нь: 1. “МИК Холдинг” ХХК-ийн 2015 оны ашиг болох нийт 4,995,087,984 төгрөгийг компанийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй энгийн нэг хувьцаанд ноогдох ашгийн хэмжээг 241.2 төгрөгөөр тооцож ногдол ашигт хуваарилахаар тогтоосугай. 2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Бүртгэлийн өдрөөр буюу 2016 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр тогтоосугай. 3. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд 2016 оны 5 дугаар сарын 02-ний өдрөөс эхлэн тараахаар тооцож “Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-тай зохих гэрээ байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Д.Гантөмс) -д үүрэг болгосугай. 4. Ногдол ашиг хуваарилалтын тайланг зохих хугацаанд гаргаж Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлэхийг ТУЗ-ийн ажлын алба (Ж.Онон) -д даалгасугай. 5. Энэхүү тогтоолын хэрэгжигчтэнд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга (М.Мөнхбаатар), ТУЗ-ийн ажлын алба (Ж.Онон) -д үүрэг болгосугай. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга М.Мөнхбаатар гэсэн байна.

Тогтоолыг танилцууллаа тогтоолтой холбоотой асуулт байна уу? “МИК Холдинг” ХК компани нь үйл ажиллагаа явуулаад удаагүй байгаа бөгөөд тус компанийн охин компани болох “МИК ОССК” ХХК-ийн 2015 оны үйл ажиллагааны татварын дараах ашгийг “МИК Холдинг” ХК-д хуваарилаад тус компани нь хувьцаа эзэмшигчдэдээ ноогдол ашиг тарааж байгаа үйл явдал юм.

- Э.Алтаншагай: “МИК Холдинг” ХК-ийн нийт ашиг нь 30 тэрбум төгрөг үүнээс 4 тэрбум 900 сая төгрөгийг “МИК Холдинг” ХК-рүү шилжүүлээд үлдсэн ашгийг хэзээ тараах вэ?
- Л.Гантөмөр: Үлдсэн ашиг нь ТЗК-ийн ашиг буюу мөнгөн хөрөнгийг өмнө нь тайлбарласанчлан ТЗК-ийг татан буулгасны дараа тараах боломжтой.

Гуравдугаар асуудал: Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг батлах тухай.

Асуудал танилцуулсан хүний нэр, албан тушаал: Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Л.Гантөмөр.

Асуудал хэлэлцэхэд оролцсон хүмүүсийн нэр, албан тушаал:

Хэлэлцэж байгаа асуудлаар асуулт асууж, санал гаргасан хүмүүсийн нэр албан тушаал, асуулт ба гаргасан саналын талаарх тэмдэглэл

Л.Гантөмөр: Гуравдугаар асуудал компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэнэ. Компанийн дүрмийн 5.1 дэх хэсэг, “компани нь нэг бүр нь 1000 төгрөгийн үнэтэй 30,000,000 ширхэг зарласан энгийн хувьцаатай байна” гэсэн заалтыг “компани нэг бүр нь 1000 төгрөгийн үнэтэй 30,000,000 ширхэг зарласан энгийн хувьцаатай бөгөөд түүнээс 20,709,320 байна” гэж өөрчлөх саналыг ТУЗ-өөс оруулж байгаа.

Т.Т.Цогтбаяр: Энэ дүрмийн 5.1 гэдэг заалт хэвээрээ байгаад 5.1.1 гээд нэмж оруулж болохгүй юу? Дараа нь тус тусд нь өөрчлөхөд амархан. Нэг заалтаа л өөрчлөөд явна.

Л.Гантөмөр: Бид нар энэ хэсгийг яагаад ингэж зохицуулах гээд байна гэхээр 5.1.1, 5.1.2 гээд шинэ заалт оруулахаар доошоо бүх заалтын дугаарлалт нь өөрчлөгдөөд явна. Хэрэв энэ зарлагдсан хувьцааны тоо нь өөрчлөгдөөд явбал ялгаагүй Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж санал авч өөрчлөгдөх учраас дүрмийн дугаарлалтад өөрчлөлт оруулахгүй гэж үзсэн байгаа.

Э.Алтаншагай: Компанийн тухай хуульд байдаг. Зарласан хувьцаа, гаргасан хувьцаа гээд 5.а, 5.б гээд явдаг.

Л.Гантөмөр: Бид нар ярилцаад зарласан хувьцаа нь 30,000,000 байна гаргасан хувьцаа нь 20,709,320 байна гээд хэрэв өөрчлөл оруулах шаардлагатай бол Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж өөрчлөлт оруулна.

Т.Цогтбаяр: Чанарын хувьд хоёулаа ялгаатай. Найруулга гэдэг бол дараа нь өөрчилж болно. Гаргасан хувьцаа болон зарласан хувьцаагаа тус тусд нь зааж өг. Логикийн хувьд ч тийм байна. Компанийн хуульд ч байгаа.

Л.Гантөмөр: Дүрмийн заалтын өөрчлөлт бол хувьцаа эзэмшигч та нарын асуудал бид нар өөрчлөх зохицуулалт бол байхгүй.

Б.Дэлгэржаргал: Энэ дүрмийн заалттай холбоотойгоор Хас банкны зүгээс 2015 оны 12-р сарын 10-ны өдөр МИК-д хандан дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа явуулсан байгаа. Энэ асуудал хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалтаар санал ирүүлсэн байсан. Капитал, Голомт зэрэг банкуудын саналыг тусган ирүүлсэн байсан. Энэ санал юу болсон бэ? Тодруулах хүсэлтэй байна. ХК нь өөрийн онцлогтой байгаа. 61 гаруй хувь нь нэгдмэл сонирхолтой этгээд байгаа. Иймд хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болох тодорхой асуудлыг эчнээгээр бус заавал хуралдаж шийдвэрлүүлэх, мөн шинээр хувьцаа гаргах, компанийн чиглэлийг өөрчлөх зэрэг асуудлыг ТУЗ-ийн хурлаар биш Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх ёстой гэж

үзсэн. Түүнээс гадна Хувьцаа эзэмшигчдийн хурал 51% -ийн ирцтэй байж хүчин төгөлдөр болж байгаа. Том хувьцаа эзэмшигчид дангаараа асуудлыг шийдвэрлэх боломжтой учраас хурлын хүчин төгөлдөр болох хувийг 75% болгох гэсэн асуудал яригдсан. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж байгаа асуудлыг 75%-ийн саналаар шийдвэрлэдэг больё гэсэн саналуудыг хүргүүлсэн байсан. Энэ дээр бид нарт тодорхой хариу ирээгүй байгаа. Энэ дээр та нар тайлбар өгнө үү?

Л.Гантөмөр: Хуулийн хэлтсээс тайлбар өгөх үү?

Б.Дэлгэржаргал: Одоо тайлбар өгөх боломжгүй байгаа бол дараа хариу өгөхийг хүсэж байна. Энэ асуудлыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцээгүй юм шиг байна. Дээр дурьдсан банкуудаас өгсөн санал эчнээ санал хураалтаар цуцлагдаад байсан. Дээрх саналуудыг тусгах ёстой гэж бодож байна. Энэ асуудал дээр хариу өгөхийг хүсэж байна.

Л.Гантөмөр: За тэгье. Дүрмийн өөрчлөлттэй холбоотой хэд хэдэн удаа Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар санал авсан байгаа. Яагаад дүрэмд нэмэлт өөрчлөлт ороогүй гэхээр хувьцаа эзэмшигчдийн өөрийн саналын шийдвэрээс гарж байгаа асуудал байгаа.

Б.Дэлгэржаргал: Манай өгсөн саналыг хувьцаа эзэмшигчдэд танилцуулаад санал хураах ёстой. Өөрөөр хэлбэл эчнээгээр санал хураахгүй байх ёстой асуудлыг дүрэмдээ тусгая, мөн манай өгсөн саналыг хувьцаа эзэмшигчдэд танилцуулж санал хураах ажил хийгдээгүй, бид нарын санал хэлэлцэгдээгүй хаана үлдсэн бэ? гэдэг асуудал ярьж байна.

Л.Гантөмөр: Энэ асуудлыг ТУЗ-өөр хэлэлцээгүй бол нөхөж хэлэлцүүлэе.

Э.Алтаншагай: Сая 61%-г нэгдмэл сонирхолтой этгээдүүд байна гээд байна. 75%-иас дээш ирцтэй байж хурал хүчин төгөлдөр болно гээд байна хариу өгнө үү?

Л.Гантөмөр: Тэрийг бол хувьцаа эзэмшигчид өөрснөө л шийднэ. Тэр асуудлын бол ТУЗ болон компанийн гүйцэтгэх удирдлага шийдэхгүй. ТУЗ тухайн саналыг нийт хувьцаа эзэмшигчдэд тараагаад ийм өөрчлөлт оруулъя гэсэн хүсэлт ирэхээр та бүхэн саналаа ирүүлнэ үү? Тэгээр энэ асуудал яаж шийдэгдэж байна гэхээр хувьцаа эзэмшигчдийн эрхийн тоогоор шийдэгдэнэ л гэсэн үг.

Э.Алтаншагай: 61%-ин нэгдмэл сонирхолтой этгээд гээд байна.

Л.Гантөмөр: Нэгдмэл сонирхолтой этгээд гэж аль алийг хэлээд байна.

Б.Дэлгэржаргал: Улаанбаатар хотын банк, Юнайтэд Секьюритис ХХК, Худалдаа хөгжлийн банк, Ти Ди Капитал ХХК зэрэг газрууд нэгдмэл сонирхолтой этгээд байгаа.

Л.Гантөмөр: Нэгдмэл сонирхолтой итгээд гэж хооронд нь холбож гаргасан дүгнэлт бол байдаггүй байх. Худалдаа хөгжлийн банк бол Ти Ди Капитал ХХК тай бол нэгдмэл сонирхолтой байгаа. Ти Ди Капитал ХХК яагаад компанийн хувьцаа эзэмшигч болсон бэ гэвэл “МИК Холдинг” ХК-ийн IPO хийхдээ тус компани нь андрайтераар ажилсан. Ямар үүрэгтэй ажилласан бэ гэхээр танай хувьцааг зах зээлд борлуулж өгнө. Борлуулаагүй хэсгийг нь бид өөрснөө худалдаж авна гэсэн үүрэгтэй байсан. Тэр үүргийнхээ дагуу хувьцаа эзэмшигч болсон байгаа. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.3. дах хэсэг, 8.3.7. дах заалт “МИК Холдинг” ХК-ийн 2016 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 16/23 тоот тогтоолыг тус тус үндэслэн “МИК Холдинг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоох нь: 1. Компанийн дүрмийн 5.1 дэх хэсэгт “Компани нь нэг бүр нь 1,000 (нэг мянга) төгрөгийн үнэтэй 30,000,000 (гучин сая) ширхэг зарласан энгийн хувьцаатай байна” гэснийг “Компани нь нэг бүр нь 1,000 (нэг мянга) төгрөгийн үнэтэй 30,000,000 (гучин сая) ширхэг зарласан энгийн хувьцаатай бөгөөд түүнээс 20,709,320 (хорин сая долоон зуун есөн мянга гурван зуун хорь) ширхэг энгийн хувьцаа гаргасан байна” гэж өөрчилсүгэй. 2. “МИК Холдинг” ХК-ийн дүрэмд орсон өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа хуулийн этгээдийн бүртгэлийн газар бүртгүүлж холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэхийг “МИК Холдинг” ХК-ийн Гүйцэтгэх захирал (Д.Гантөгс)-д даалгасугай. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Л.Гантөмөр гэсэн байна.

- Т.Т.Цогтбаяр: Миний оруулсан саналыг яагаад асуухгүй байгаа вэ? Та ганцаараа хариулаад байна, бусад нь хариулахгүй байна. Найруулгын хувьд ингээд өөрчилье гээд санал авч л даа.
- Л.Гантөмөр: Зөв найруулгын асуудал байна гээд хувьцаа эзэмшигчдээс дахиад санал авч болно.
- Т.Т.Цогтбаяр: Энэ тогтоол дээр саналаа өгөх гээд байна. Гол нь агуулга найруулгын хувьд ингээд өөрчилье гээд, санал өгүүлмээр байна. Та хувьцаа эзэмшигчдийн асуудал гээд ганцаараа яриад хүмүүсээс санал авахгүй байна.
- Э.Алтаншагай: Ер нь бол зарласан хувьцаа 30,000,000 гаргасан нь тэд гээд дахиад нэг заалт оруулж ирэх нь зөв байх, нийт багц биш тус тусд нь гэдэг санал гаргаад байна.
- Л.Гантөмөр: Зарлах ёстой хувьцаагаа зарласан, зарласан болон гаргасан хувьцаанд өөрчлөлт оруулах ёстой бол ялгаагүй хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол гарна. Том ач холбогдол олж харахгүй байна. Зарлах ёстой юм уу гэдгийг дүрэмдээ тусгалаа.5.1 гэх үү? 5.а гэх үү ийм санал гаргаж байна. Хувьцаа эзэмшигчид шийдэх байх. ТУЗ-өөс оруулж ирж байгаа тогтоолын төсөл бол хуулийн дагуу хувьцаагаа зарлаад ингэж өөрчлөлт оруулах боломжтой юм байна гэж харсан.
- Т.Т.Цогтбаяр: Тогтоолын төслөө гар өргөөд баталъя.
- Л.Гантөмөр: Үүнийг саналын хуудсаар саналаа өгөх хэрэгтэй.
- Т.Т.Цогтбаяр: Саналын хуудас бол үүнийг зөвшөөрнө гэсэн үг. Хэлбэр нь энэ зөв үү гэдгийг гар өргөөд шийдье. Хэлбэр нь биш байна гэж хэлээд байна.
- Л.Гантөмөр: Тооллогын комисс ажиллах шаардлага байна уу?
- Т.Т.Цогтбаяр: Тооллогын комисс ажиллах шаардлагагүй агуулга нь зөв байна гээд гар өргөөд боллоо. Хүлээн зөвшөөрөх гээд байна.
- Л.Гантөмөр: Би болохоор оруулж ирж байгаа асуудлаа яриад байна.
- Т.Т.Цогтбаяр: Бусад нь дэмжиж байна уу? Бөгөөд гэдэг үгээр тоглодог тохиолдол гардаг. “Улаанбаатар АЗЗА” төрийн өмчит компани байна. 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, сая ширхэг хувьцаатай гэсэн мөртөө 1000 төгрөг болгоод 10 тэрбум ширхэг болгоод компанийн баланс нь зөрсөн газар байгаа. Тэгээд компаниа хуваагаад гаргасан хувьцааны талаараа ярьдаггүй гэх мэт асуудал үүсдэг.
- Л.Гантөмөр: Тэгвэл өөрчлөлт хийх шаардлагатай гэдэг нь гараа өргөх үү?
- Т.Т.Цогтбаяр: За би ганцаараа юм байна.

Дөрөвдүгээр асуудал: Компанийн ТУЗ-ийн зардлын 2016 оны төсвийн батлах тухай;

Асуудал танилцуулсан хүний нэр, албан тушаал: Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга МИК Холдинг ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Л.Гантөмөр.

Асуудал хэлэлцэхэд оролцсон хүмүүсийн нэр, албан тушаал:

Хэлэлцээж байгаа асуудлаар асуулт асууж, санал гаргасан хүмүүсийн нэр албан тушаал, асуулт ба гаргасан саналын талаарх тэмдэглэл

- Л.Гантөмөр: Компанийн ТУЗ-ийн зардлын 2016 оны төсвийн төслийг батлах тухай асуудал байгаа. Нийтдээ 321.9 сая төгрөгийн төсөв байгаа бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн цалин болон дэргэдэх хороодын цалингийн зардал болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын төсөв байгаа. Зардлын төсөвтэй холбоотой санал асуулт байна уу?
- Д.Өлзийбат: Санал байна. ТУЗ-ийн дарга, гишүүд болон хороодын цалингийн зэрэглэл зөрөөтэй байна. Хороодын гишүүд нь бол жинхэнэ ажил хийдэг хүмүүс байгаа яагаад ийм зөрөөтэй байна вэ? Үндэслэлтэй тайлбар өгөх боломж байна уу?
- Л.Гантөмөр: 2015 онд бол ТУЗ-ийн даргын цалин 2 сая төгрөг, гишүүдийн цалин 1 сая 500 мянган төгрөг байсан. 2016 оноос яагаад нэмэгдүүлэх шаардлага гарсан бэ гэхээр одоо ажиллаж байгаа 9 ТУЗ-ийн гишүүн “МИК Холдинг” ХК болон “МИК ОССК” ХХК гээд 2 компанийн ТУЗ-ийн үүргийг хамтран гүйцэтгэж байгаа. Мөн ТУЗ-ийн дэргэд 4 хороо

ажиллаж байгаа. Энэ нь ТУЗ-ийн гишүүнээс гадна бусад холбоотой ажилладаг банкуудын 4 гишүүнээс бүрдсэн байгаа. Зөвхөн ТУЗ-ийн гишүүд биш энэ хороодод ажиллаж байгаа хорооны гишүүдийн цалин бас яригдаж байгаа.

Э.Алтаншагай: Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргыг та хийж байгаа юу?

Л.Гантөмөр: Тийм, өнөөдрийн хурлын даргыг бол би хийж байгаа, ТУЗ-ийн даргаар М. Мөнхбаатар гэдэг гишүүн ажиллаж байгаа.

Э.Алтаншагай: Гарын үсэг зурахдаа таны нэр өөрчлөгдөх үү?

Л.Гантөмөр: Энэ бол өмнө нь тараагдсан материал учраас нэр нь солигдоогүй байгаа, өнөөдрийн хурлын шийдвэр дээр би гарын үсэг зурж баталгаажуулна.

Д.Өлзийбат: Энэ төсөв дээр 2016-2017 он хүртэл гээд бичсэн байна. Ямар учиртай юм бэ?

Л.Гантөмөр: Энэ бол дараагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл буюу 4 дүгээр сарын 30 хүртэлх төсөв байгаа. 2016 гарах зардлыг ялгаад өгсөн байгаа.

Д.Өлзийбат: Бид энэ хурал дээр жилд нэг удаа саналаа хэлэх эрхтэй байгаа. Гадуур эдийн засгийн нөхцөл байдал хэр байгаа билээ. Энэ цалингийн төсвийг багасгах асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дахин хэлэлцүүлэх боломж байна уу?

Л.Гантөмөр: “МИК ОССК” ХХК-ийн хурал ойролцоогоор сард 4-5 удаа хуралддаг байгаа, дэргэдэх хороодын хурал сард 3-4 удаа хуралддаг. Хурлаар хэлэлцэх асуудал маш их байдаг. Компанийн дотоод үйл ажиллагаанд илүү түлхэц өгч ажилладаг мөн дээрээс нь “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн ажлыг хийж байгаа. “МИК ОССК” ХХК-ийн ТУЗ-ийн ажлыг давхар хийж байгаа учраас энэ цалинг бол өндөр тогтоосон гэж харахгүй байгаа.

Д.Өлзийбаяр: Гурван компанийн ТУЗ-ийн ажлыг 9 гишүүнтэй ТУЗ хийж байна гэж яриад байна. Энэ талаарх тайланг аваагүй. МИК ОССК ХХК-ийн зардал дээр нь дахиад ийм зардал явж байж болзошгүй гэсэн болгоомжлол байна. Үүнийг тунгалаг болгох гэсэн бодол яваад байна. Түүнээс энэ цалинг их байна гэсэн асуудал биш.

Л.Гантөмөр: ТУЗ-ийн гишүүд бол зөвхөн “МИК Холдинг” ХК-иас л цалинжина. “МИК ОССК” ХХК-иас бол цалинжихгүй. Гэхдээ ТУЗ-ийн гишүүнийг нь давхар хийгээд явж байгаа. Энэ бол тайлангаар гарж байгаа зардлууд байгаа.

Т.Т.Цогтбаяр: Цаашид бол ТУЗ-ийн гишүүд хурлуудад хэдэн удаа оролцсон эсэх, мөн зөвхөн ТУЗ-ийн гишүүдийн цалин биш томилолтын зардал, Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал бас орсон байгаа байх эдгээрийг тайландаа харуулах хэрэгтэй байх. Дараа тайлангаа танилцуулахдаа ТУЗ-ийн гишүүд хэдэн удаа хуралдах ёстой байснаас хэдэд нь оролцоод хэдийг нь тасалсан гэдгийг илэрхий тоотой байх ёстой. Нэг гишүүн аль аль дэд хороодод байдаг гэдгээ бас тодорхой тайлангнах хэрэгтэй.

Л.Гантөмөр: МИК-ийн ТУЗ-ийн гишүүдийн нэрлэсэн цалинг тухайн сард хуралд хэдэн удаа оролцсон ирц дээр нь үндэслэн бодож олгодог байгаа. Яг бүтнээр нь авна гэсэн зохицуулал бол байхгүй.

Б.Гантулга: Би том юм ярихгүй, хувьцааны үнэ доошлоод байна. Анх 12000 төгрөгөөр авсан. Анх нэрлэсэн үнэ нь өндөр байсан одоо буураад байна. IPO хийсэн компани нь амьдралтай ойр илүү бодитой хийх хэрэгтэй байсан болов уу үүнийг анхаарах хэрэгтэй. Улс орны нөхцөл байдал хүмүүсийн авах чадвар зэрэгт нийцүүлэн хийх хэрэгтэй байсан болов уу. Хувьцааны үнэ унаж байгаа нь компанийн хувьд муу үзүүлэлт байх. ХК-г хараад байхад хувьцааныхаа үнийг бууруулаад илүү олон хүнд хүртээмжтэй болгодог байгаа. Олон хувьцаа эзэмшигчтэй бол илүү үр дүнтэй болох байх. Үүнийг ТУЗ нь бас анхаарах хэрэгтэй.

Э.Алтаншагай: Ногдол ашиг гэж өгсөн байгаа, тайлан дээр нийт ашиг нь 30 тэрбум төгрөг гэж гараад байна. Үүнээс ирээдүйн тэтгэврийн санд мөнгө шилжүүлсэн гэж ойлгоод байна

Л.Гантөмөр: Тэр шилжүүлсэн нь мөнгө биш үнэт цаасны багц байгаа, тайлангаас харвал баталгаажсан бонд гээд 19-р хуудсанд 2 их наяд төгрөг гээд байгаа үүнд байгаа бондын багцыг бид ирээдүйн тэтгэврийн санд шилжүүлсэн байгаа. Энэ бондын багцын

эзэмшигч нь Монголбанк байсныг санруу шилжүүлээд эзэмшигчийг нь өөрчилж байгаа бөгөөд бондын эргэн төлөлтийг санруу шилжүүлж байгаа л гэсэн үг.

Э.Алтаншагай: За компанийн тухай хуульд 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар гэж хэлэлцдэг үү?

Л.Гантөмөр: Үгүй, ТУЗ-өөр хэлэлцээд явдаг байгаа.

Т.Т.Цогтбаяр: Энэ асуудал ТУЗ-ийн асуудал байдаг.

Л.Гантөмөр: Нэмэлт асуудал байна уу? Байхгүй бол саналын хуудсаа тооллогын комисст өгнө үү?

Л.Гантөмөр: Тооллогын комисс дүнг танилцуулна.

С.Амарсайхан: Санал хураахын өмнөх ирцийг шинэчлэн танилцуулъя. Нийт 19.930.489 хувьцаа эзэмшигч нийт 96.24 хувийн санал ирүүлсэн байна.

Нэгдүгээр асуудалд өгсөн санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн дүнг танилцуулъя. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай, нийт санал өгсөн 19.930.489 хувьцаа эзэмшигч санал өгснөөс 100 хувийн саналаар батлахыг зөвшөөрсөн байна.

Хоёрдугаар асуудал. Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг батлах тухай асуудалд нийт 18.249.450 хувьцаа эзэмшигчдийн 92% нь зөвшөөрч, 1.688.38 буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 8% нь түдгэлзсэн санал өгсөн байна.

Гуравдугаар асуудал, Компанийн ТУЗ-ийн зардлын 2016 оны төсвийн төслийг батлах тухай; нийт 19.930.472 ширхэг хувьцаа эзэмшигчдийн 99.9 хувь нь зөвшөөрсөн, 17 ширхэг хувьцаа эзэмшигч татгалзсан, 1 түдгэлзсэн санал өгсөн байна.


Л.Гантөмөр: Тооллогын комиссын дарга Амарсайханд баярлалаа. Нийт хувьцаа эзэмшигчдээ хуралд оролцсонд баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын
дарга тэмдэглэл хөтөлсөн:



Г.Саруул
ТУЗ-ийн нарын бичгийн дарга

Хувьцаа эзэмшигчдийн хурлын
дарга тэмдэглэлтэй танилцсан :



Л.Гантөмөр
Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга

МИК Холдинг “ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2016 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн
16/21 тоот тогтоолын Хавсралт №1

“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр: “МИК Холдинг” ХК

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо 13 хороолол, Энхтайвны өргөн чөлөө-19, 10-р давхар

Хурал хуралдах огноо, цаг, газар: 2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 10:00 цагт
“МИК ОССК” ХХК-ийн байранд (Сүхбаатар дүүрэг, 1-р хороо 13 хороолол, Энхтайвны өргөн
чөлөө-19, 10-р давхар, 1007 тоот)

Хуралд хуралдах шийдвэр гаргасан огноо: 2016 оны 3 дугаар сарын 18-ны өдөр

Олон нийтэд зарлах огноо: 2016 оны 3 дугаар сарын 21-ны өдөр

Бүртгэх өдөр: 2016 оны 3 дугаар сарын 31-ний өдөр

Хурлын баримт, бичгийг брокер дилерийн компанид хүргүүлэх огноо: 2016 оны 3 дугаар
сарын 25-ны өдөр.

Хүргүүлсэн огноо: 2016 оны 3 дугаар сарын 21-ний өдөр

Хурлын баримт, бичгийн хуудасны тоо _____ ширхэг, _____ хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА/...../

2016 оны ____ дугаар сарын ____-ний өдөр

ХҮЛЭЭН АВСАН БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН /...../

2016 оны ____ дугаар сарын ____-ний өдөр